

ЖОР БИЧИЛТИЙН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнөөс гарсан 2019 онд хэрэгжүүлэх 8/20 зорилтын 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, ЭМХТ-өөс ирүүлсэн №1541 тоот албан бичгийн дагуу Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартын хэрэгжилтэд хяналтын хуудсын дагуу үнэлгээг хийв. Хяналтын хуудсыг 30 эмийн санд хүргүүлснээс 20 эмийн сан хяналтад хамрагдлаа.

Хяналтын үнэлгээгээр дараах асуудлууд стандартын шаардлага хангахгүй байна. Үүнд:

1. Эмийн сангийн хүний нөөцийн байдал сумдад хангалтгүй буюу 2-р зэрэглэлийн эмийн санд эмийн мэргэжилтэн нэг ажиллаж байна.
2. Эмийн гаж нөлөө бүртгэх хайрцаг, шар хуудсыг эмийн сангууд тушаалын дагуу байрлуулсан байгаа боловч эмнэлгийн болон иргэдийн мэдлэг хангалтгүйгээс бүртгэгдсэн гаж нөлөө 1 эмийн сангаас бусад эмийн санд бүртгэгдээгүй байна.
3. Эмч нарын өвчний картан дээр бичсэн эмийг эмийн сангаас олгосоор байгаа нь жоргүй эм олголтын хувийг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан нь болж байна. Ийм тохиолдолд эмчийн заалтгүй олгогдсон гэх үндэслэлгүй, нөгөө талаас жор бичүүлж ирэх шаардлага тавихад иргэдээс их бухимдал үүсдэг зэрэг хүндрэлтэй асуудлууд байсаар байна. Аймгийн хэмжээнд жил бүр антибиотикийн зохистой хэрэглээг суртачилах, жороор олголтыг нэмэгдүүлэх сургалт суртачилгааны ажлыг хийж ажилласнаар иргэдийн дунд антибиотикийг жоргүй авах хандлага буурч байна.

Цаашид авч хэрэгжүүлэх санал:

1. Эмийн сангийн мэргэжлийн хүн хүчний хангамжийн мэдээний санг орон нутагт бүрдүүлж байгаа боловч шилжилт хөдөлгөөн маш их байна. Иймд эмийн мэргэжилтнүүдийн цахим бүртгэлийн системийг яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байна.
2. Өрх, сумын анхан шатны тусламж үйлчилгээнд эмийн жорын цахим системийг ЭМД-ын системтэй уялдуулан цахимжуулбал жор бичилт сайжрах боломжтой.
3. Эмч нарын жор бичих хариуцлагын тогтолцоог одоогийнхоос илүү сайжруулах, эсвэл жор бичих тогтолцоог өөрчлөх. Эмч нарын ажлын ачаалал их, бичих бөглөх баримт их байдаг.

Өмнөговь оны эм зүйн үзүүлэлт - 2019 он

№	Эмийн сангийн нэрс хяналтын асуулууд	Агарфари эмийн сан	Ундар	Энхмэнд	хулан	хайрхан	Эн хангамж	Ганга	Тун-Эрдэнэ	Мөнхийн рашаан	Манхуг	Зууннаст	сүдбалар	жаргалфарм	Оюу	Говь	Ингэнүд	Аврагтовь	Элементговь	Сүжийговь	Нөрөөгтовь	Аймгийн хэмжээнд стандартын хэрэгжилт	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20		
1	Тусгай зөвшөөрөлтэй эсэх а.Хүчинтэй б.Хүчингүй	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
2	Эмийн сангийн орон тоо стандартын дагуу эсэх	7	10	10	8	10	7	10	7	10	10	8	10	10	10	10	10	10	10	7	7	7	8.6
4	Эмийн гаж нөлөөний бүртгэл /шар хуудас, хайрцагтай эсэх/	8	9	9	9	5	5	9	7	8	8	8	10	8	9	7	7	7	7	7	7	7	7.3
5	Эмийн үнэ ил тод байрлуулсан эсэх	5	8	9	9	0	3	8	8	8	8	0	10	9	9	8	8	8	8	8	8	8	6.8
6	Кассын машин	10	10	10	10	6	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	9.3
7	Эмийн санд зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь	10	10	10	9	5	8	9	9	7	8	5	8	10	10	9	7	8	9	9	9	9	8.0
10	Жороор олгох эмийг жоргүй олгосон тоо /эмийн нэр/	5	8	8	0	5	0	0	0	8	10	10	10	7	10	10	0	0	10	10	10	10	6.1
11	Хүлээн авсан хүчингүй жорын тоо	5	10	10	10	5	5	7	5	7	8	8	10	10	8	8		10	8	8	8	8	7.5
12	Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2016 стандартын дагуу өрх дүүрэг хувийн болон бусад ЭМБ-д мэдээлэл сургалт, хамтран ажиллах төлөвлөгөөтэй эсэх	8	8	8	9	0	8	10	10	10	10	10	10	9	10	9	10	8	10	0	0	0	7.9
13	Иргэд, эрүүл мэндийн байгууллагад зориулсан нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний санамж, гарын авлага, самбар мэдээлэл ажиллуулдаг эсэх	3	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	9	10	10	10	0	4	4	8.8
14	Эмийн жорыг архивладаг /журам/	6	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	8	10	10	10	8	8	8	9.5
15	Дотоод хяналтын төлөвлөгөөтэй, хяналт тавьдаг эсэх	7	9	9	7	7	7	9	9	9	9	6	10	7	10	10	6	9	10	7	7	7	8.2
НИЙТ ОНОО		84	112	113	101	73	83	102	95	107	111	95	118	110	116	108	88	100	112	84	88	100.0	
хувиар		56.0	74.7	75.3	67.3	48.7	55.3	68.0	63.3	71.3	74.0	63.3	78.7	73.3	77.3	72.0	58.7	66.7	74.7	56.0	58.7	66.7	
дундаж оноо		5.6	7.5	7.5	6.7	4.9	5.5	6.8	6.3	7.1	7.4	6.3	7.9	7.3	7.7	7.2	5.9	6.7	7.5	5.6	5.9	6.7	

Өмнөговь оны эм зүйн үзүүлэлт - 2019 он

Судалгаанд 20 эмийн санд 3-р улирлын байдлаар хүлээн авсан 6633 жорыг хамруулсан. Судалгаагаар эмийн сангийн стандартын хэрэгжилт 85%-иар үнэлэгдсэн. Эмийн жор бичилтийн стандартын хэрэгжилт 89,7%-иар хэрэгжиж байна.